

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци
ХК	Хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА – 3
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Г.ЗОЛБОО ТАНАА

2021.02.25 № 07/540
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тогтвортой амьжиргаа -3 төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төслийн удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Төслийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүрэлдэхүүн хэсгийн нийт 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, 4 ажил төлөвлөсөн хугацааны дагуу хэрэгжиж байгаа, 1 ажлыг хэрэгжүүлээгүй буюу 95 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,146,956,141.95</u>	<u>1,351,225,947.60</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,146,956,141.95	1,180,820,947.60
Кассанд байгаа бэлэн мөнгө	300,291.86	8,951.86
Төгрөг	300,291.86	8,951.86
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,146,655,850.09	1,180,811,995.74
Төгрөг	717,076,484.55	334,710,097.41
Төрийн сангийн харилцах	712,842,054.68	330,495,667.54
Арилжааны банк дахь харилцах	4,234,429.87	4,214,429.87
Гадаад валют	429,579,365.54	846,101,898.33
Төрийн сангийн харилцах	429,579,365.54	846,101,898.33
БАРАА МАТЕРИАЛ	-	170,405,000.00
Бэлэн бүтээгдэхүүн	-	170,405,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>248,530,200.81</u>	<u>183,253,871.85</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	248,530,200.81	183,253,871.85
Биет хөрөнгө	246,898,950.81	183,197,621.85
Авто-тээврийн хэрэгсэл	162,300,000.00	162,300,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(99,597,222.25)	(107,786,111.09)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	232,433,690.00	232,433,690.00
Хуримтлагдсан элэгдэл	(112,993,883.00)	(159,552,171.00)
Тавилга, аж ахуйн эд хогшил	92,114,654.54	92,114,654.54
Хуримтлагдсан элэгдэл	(27,358,288.48)	(36,312,440.60)
Биет бус хөрөнгө	1,631,250.00	56,250.00
Програм хангамж	6,300,000.00	6,300,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(4,668,750.00)	(6,243,750.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,395,486,342.76</u>	<u>1,534,479,819.45</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>307,027,290.72</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	307,027,290.72
Өглөг	-	307,027,290.72
Бусад өглөг	-	307,027,290.72
Байгууллагад төлөх өглөг	-	307,027,290.72
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,395,486,342.76</u>	<u>1,227,452,528.73</u>
Засгийн газрын хувь оролцоо	1,395,486,342.76	1,227,452,528.73
Хуримтлагдсан үр дүн	1,395,486,342.76	1,208,591,417.57
Өмнөх үеийн үр дүн	2,180,843,204.72	1,395,486,342.75
Тайлант үеийн үр дүн	(785,356,861.96)	(186,894,925.18)
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	18,861,111.16
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,395,486,342.76</u>	<u>1,534,479,819.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,745,614,181.90	14,712,461,603.44
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,745,614,181.90	14,712,461,603.44
Нийтлэг татварын бус орлого	40,482,163.15	6,052,455.46
Төсөвт байгууллагын өөрийн орлого	40,482,163.15	6,052,455.46
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,662,718.73	6,052,455.46
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,819,444.42	-
Тусламжийн орлого	4,104,358,780.59	3,925,031,464.74
Хандив тусламж /гадаад/	4,104,358,780.59	3,925,031,464.74
Зээлийн орлого	15,600,773,238.16	10,781,377,683.24
Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	15,600,773,238.16	10,781,377,683.24
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	20,499,944,782.18	14,923,241,872.55
УРСГАЛ ЗАРДАЛ	20,499,944,782.18	14,923,241,872.55
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,295,890,063.45	2,858,214,117.09
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	538,045,908.82
Үндсэн цалин	-	538,045,908.82
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	67,952,438.64
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	67,952,438.64
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	45,000,000.00
Байрны түрээс	-	45,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	16,118,596.81	25,111,235.95
Бичиг хэрэг	250,111.73	2,562,336.33
Тээвэр, шатахуун	6,387,627.27	5,719,600.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	5,769,957.81	6,561,352.87
Ном, хэвлэл	3,710,900.00	5,879,568.16
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,388,378.59
Томилолт, зочны зардал	9,894,723.00	3,312,000.00
Дотоод албан томилолт	9,894,723.00	3,312,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,122,308,719.62	2,063,699,629.75
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,122,308,719.62	2,063,699,629.75
Бараа үйлчилгээний бусад зардал	147,568,024.02	115,092,903.93
Бараа үйлчилгээний бусад зардал	71,538,622.39	30,955,463.81
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,029,401.63	84,137,440.12
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,204,054,718.73	12,065,027,755.46
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,662,718.73	6,052,455.46
Төвлөрүүлэх шилжүүлэг	25,662,718.73	6,052,455.46
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,178,392,000.00	12,058,975,300.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	15,178,392,000.00	12,058,975,300.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(754,330,600.28)	(210,780,269.11)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,026,261.68	(23,885,343.93)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	31,026,261.68	(23,885,343.93)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(31,026,261.68)	23,885,343.93
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(785,356,861.96)	(186,894,925.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	19,730,794,737.48	14,712,461,603.44
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,730,794,737.48	14,712,461,603.44
Нийтлэг татварын бус орлого	25,662,718.73	6,052,455.46
Төсөв байгууллагын өөрийн орлого	25,662,718.73	6,052,455.46
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,662,718.73	6,052,455.46
Тусламжийн орлого	4,104,358,780.59	3,925,031,464.74
Хандив тусламж /гадаад/	4,104,358,780.59	3,925,031,464.74
Зээлийн орлого	15,600,773,238.16	10,781,377,683.24
Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	15,600,773,238.16	10,781,377,683.24
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	20,449,982,398.55	14,424,722,097.71
УРСГАЛ ЗАРДАЛ	20,449,982,398.55	14,424,722,097.71
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,245,927,679.82	2,359,694,342.25
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	405,586,748.55
Үндсэн цалин	-	405,586,748.55
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	54,012,313.64
Тэтгэврийн даатгал	-	21,596,625.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	32,415,688.64
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	33,750,000.00
Байрны түрээс	-	33,750,000.00
Хангамж, бараа материалын зардал	15,927,596.81	32,611,235.95
Бичиг хэрэг	250,111.73	2,562,336.33
Тээвэр, шатахуун	6,196,627.27	5,719,600.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	5,769,957.81	14,061,352.87
Ном, хэвлэл	3,710,900.00	5,879,568.16
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,388,378.59
Томилолт, зочны зардал	9,782,425.00	3,312,000.00
Дотоод албан томилолт	9,782,425.00	3,312,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,127,815,292.27	1,795,716,580.30
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,127,815,292.27	1,795,716,580.30
Бараа үйлчилгээний бусад зардал	92,402,365.74	34,705,463.81
Бараа үйлчилгээний бусад зардал	92,402,365.74	34,705,463.81
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,204,054,718.73	12,065,027,755.46
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,204,054,718.73	12,065,027,755.46
Төвлөрүүлэх шилжүүлэг	25,662,718.73	6,052,455.46
Хөрөнгийн	15,178,392,000.00	12,058,975,300.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(719,187,661.07)	287,739,505.73
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	277,760,044.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	277,760,044.00
Дотоод эх үүсвэрээр	-	277,760,044.00
Тоног төхөөрөмж	-	277,760,044.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(277,760,044.00)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	(31,026,261.67)	23,885,343.93
Гадаад валютын ханшийн зөрүү	(31,026,261.67)	23,885,343.93
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(31,026,261.67)</u>	<u>23,885,343.93</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(750,213,922.74)	33,864,805.66
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,897,170,064.69	1,146,956,141.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,146,956,141.94	1,180,820,947.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,180,843,204.71	-	2,180,843,204.71
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,180,843,204.71	-	2,180,843,204.71
Тайлант үеийн үр дүн	-	-	(785,356,861.96)	-	(785,356,861.96)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,395,486,342.75	-	1,395,486,342.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	18,861,111.16	-	18,861,111.16
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			1,414,347,453.91	-	1,414,347,453.91
Тайлант үеийн үр дүн	-	-	(186,894,925.18)	-	(186,894,925.18)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,227,452,528.73	-	1,227,452,528.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,987,920,200.00	14,696,429,686.25	291,490,513.75	98.1
УРСГАЛ ЗАРДАЛ	14,710,160,200.00	14,418,669,642.25	291,490,557.75	98.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,651,183,000.00	2,359,694,342.25	291,488,657.75	89.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,143,600.00	405,586,748.55	11,556,851.45	97.2
Үндсэн цалин	417,143,600.00	405,586,748.55	11,556,851.45	97.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,698,000.00	54,012,313.64	685,686.36	98.7
Эрүүл мэндийн даатгал	54,698,000.00	54,012,313.64	685,686.36	98.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,750,000.00	33,750,000.00	-	100.0
Байрны түрээс	33,750,000.00	33,750,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	34,162,700.00	32,611,235.95	1,551,464.05	95.5
Бичиг хэрэг	3,562,300.00	2,562,336.33	999,963.67	71.9
Тээвэр, шатахуун	6,158,500.00	5,719,600.00	438,900.00	92.9
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	14,612,300.00	14,061,352.87	550,947.13	96.2
Ном, хэвлэл	5,879,600.00	5,879,568.16	31.84	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,950,000.00	4,388,378.59	(438,378.59)	111.1
Томилолт, зочны зардал	3,312,000.00	3,312,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	3,312,000.00	3,312,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,073,411,100.00	1,795,716,580.30	277,694,519.70	86.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,073,411,100.00	1,795,716,580.30	277,694,519.70	86.6
Бараа үйлчилгээний бусад зардал	34,705,600.00	34,705,463.81	136.19	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	34,705,600.00	34,705,463.81	136.19	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,058,977,200.00	12,058,975,300.00	1,900.00	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	12,058,977,200.00	12,058,975,300.00	1,900.00	100.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	12,058,977,200.00	12,058,975,300.00	1,900.00	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	277,760,000.00	277,760,044.00	(44.00)	100.0
Дотоод эх үүсвэрээр	277,760,000.00	277,760,044.00	(44.00)	100.0
Тоног төхөөрөмж	277,760,000.00	277,760,044.00	(44.00)	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,987,920,200.00	14,706,409,147.98	281,511,052.02	98.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,974,326,800.00	10,781,377,683.24	192,949,116.76	98.2
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,974,326,800.00	10,781,377,683.24	192,949,116.76	98.2

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,013,593,400.00	3,925,031,464.74	88,561,935.26	97.8
Хандив тусламж /гадаад/	4,013,593,400.00	3,925,031,464.74	88,561,935.26	97.8
БУСАД	-	23,885,343.93		
Гадаад валютын ханшийн зөрүү	-	23,885,343.93		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,146,956,141.94		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,180,820,947.60		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	34	34		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	26	26		
Гэрээт ажилтан	7	7		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Тогтвортой амьжиргаа – 3 төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн захирал Г.Золбоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн ашиглалтад анхаарах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 19-нөөс 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Грант Торнтон аудит ХХК-ийн Ерөнхий захирал, гэрээт ажлын партнер Б.Осоргарав, Партнер, чанарын хянагч Н.Эрдэнэцог, аудитын менежер Б.Дэлгэрмаа нар хянан удирдаж, аудитор Б.Алтансарнай, туслах аудитор Б.Тогжан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Тогтвортой амьжиргаа–3 төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Грант Торнтон аудит ХХК -д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тогтвортой амьжиргаа–3 төсөл нь Монголын хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилготой. Төслийн санхүүжилтийн хэмжээ нь Дэлхийн банк, ОУХА-ийн хөнгөлөлттэй зээл 36.8 сая америк доллар, Швейцарын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламж 5.6 сая америк доллар байна. Төсөл хэрэгжих хугацаа 2015 оны 8 дугаар сарын 01-ний 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байсныг тайлант онд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулж, 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараах үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Бүрэлдэхүүн 1: Орон нутгийн засаглал, амьжиргааны чадавхыг бэхжүүлэх. Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг төлөвлөх буюу орон нутгийн төсвийн төслийг боловсруулах ба батлах, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх буюу төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах чиглэлээр орон нутгийн төр, захиргааны байгууллага болон иргэд, олон нийтэд сургалт явуулж, мэдээлэл түгээж, чадавхыг бэхжүүлэх.
- Бүрэлдэхүүн 2: Сайн засаглал-Үр дүнд суурилсан урамшууллын хөтөлбөр. Төсөв боловсруулах, батлах, төсвийн гүйцэтгэлийг хангах, бүртгэх, тайлагнах, дотоод болон хөндлөнгийн хяналт, иргэд, олон нийтийн хяналтыг хамарсан төсөв санхүүгийн бодлого төлөвлөлтийн бүхий л үйл ажиллагаанд “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” хийж, болзол хангасан сумдад урамшууллыг олгох хэлбэрээр сайн засаглалыг бэхжүүлэх.
- Бүрэлдэхүүн 3: Төслийн удирдлага, Хяналт-Шинжилгээ, Үнэлгээ. Төслийн удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын уялдаа холбоог хангаж ажиллах, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг дэмжих, төслийн

хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг хянах системийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

Төслийн гурван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2020 онд нийт 31 үйл ажиллагааг төлөвлөж ажилласнаас 26 ажил бүрэн хэрэгжиж дуусан, 4 ажил төлөвлөсөн хугацааны дагуу хэрэгжиж байна. Ковид-19 цар тахлын хорио цээрийн дэглэмээс шалтгаалан 1 ажлыг хэрэгжүүлээгүй бөгөөд төслийн үйл ажиллагаа 95%-тай хэрэгжсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны гарын авлагыг 5 багц модуль сургалт болгон, хичээлийг видео контент хэлбэрээр бэлтгэж, цахим хэлбэрт шилжүүлсэн.
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог идэвхжүүлэх дэд төслүүдийн сайн туршлагын эмхэтгэл, орон нутагт хөгжлийг чиглүүлэх “Чиглүүлэгчийн гарын авлага”-ыг боловсруулсан.
- Олон нийтийн оролцоот худалдан авах ажиллагааны журмын төслийг шинэчлэх ажлыг эхлүүлж, журмыг сайжруулах зөвлөмж боловсруулж Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа болон төслийн үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сан болон төслийн үйл ажиллагаатай холбоотой нийт 2 шторк, 6 нэвтрүүлэг, 12 ширхэг сургалтын видео, 1 ярилцлагын нэвтрүүлгийн зураг авалт, эвлүүлэг, хийц, цацалт болон үндэсний болон орон нутгийн түвшинд 21 мэдээ бэлтгэл, цацалт хийж мөн 13 төрлийн мэдээлэл, сурталчилгааны материалыг хэвлэж, олон нийт болон сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдад түгээсэн.
- Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж оноо 2016 онд 32%, 2017 онд 37%, 2018 онд 50%, 2019 онд 59,5% байсан бол 2020 онд 60.13%-д хүрч өссөнөөр төслийн зорилтот түвшин болох 60%-аас дээш гарч шалгуур үзүүлэлтийн зорилтоо биелүүлсэн байна.
- 2020 онд 330 суманд 5.2 тэрбум төгрөгийн “ерөнхий дэмжлэг”, 2019 онд жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр болзол хангасан 248 суманд 6.5 тэрбум төгрөгийн “урамшуулал”-ын санхүүжилт олгосон байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системийг шинэчлэх ажлын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын байдлаар системийн цэсүүдийг хөгжүүлж эцэслэн системийг бүрэн ашиглалтад оруулсан байна.
- Чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2020 онд орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системийн цахим сургалт, жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, удирдлагын мэдээллийн системийн зааварчилгаа, арга зүйн сургалт, орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний аргачлал, шалгуур үзүүлэлтүүдэд орсон өөрчлөлт, төрийн албан хаагчдад зориулсан АЗ сертификат олгох цахим сургалт зэрэг сургалтуудыг зохион байгуулж нийт 2114 төрийн албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тогтвортой амьжиргаа–3 төсөл санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Дэлхийн банкнаас гаргасан “Санхүүгийн гарын авлага” болон Сангийн сайдын 2007 оны 11 сарын 30-ны өдрийн 326 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг нягтлан бодох бүртгэлд мөрдөж байна.

2020 онд Сангийн яамнаас тус төслийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 6 дугаар сарын 30-ны үр дүнгийн тайлангийн 11,185,979.2 мянган төгрөгийн нийт зардлаас 2 хувиар буюу 223,719.5 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүй.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн үр дүнгийн тайлангийн 14,923,241.9 мянган төгрөгийн нийт зардлаас 2 хувиар тооцон 298,464.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тогтвортой амьжиргаа–3 төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,993.5 мянган төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,146,956.1	1,180,820.9	33,864.8
Бараа материал	-	170,405.0	170,405.0
Үндсэн хөрөнгө	246,899.0	183,197.6	(63,701.3)
Биет бус хөрөнгө	1,631.3	56.3	(1,575.0)
Нийт хөрөнгө	1,395,486.3	1,534,479.8	138,993.5
Өр төлбөр	-	307,027.3	307,027.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,395,486.3	1,227,452.5	(168,033.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,395,486.3	1,534,479.8	138,993.5

Өмнөх оны үзүүлэлтээс дараах дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.
Тухайлбал:

Бараа материалын дансны үлдэгдэл 170,405.0 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор худалдан авсан гарын авлага, таниулах материалын үлдэгдлийг бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 183,197.6 мянган төгрөг болж 63,701.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 56.3 мянган төгрөг болж 1,575.0 мянган төгрөгөөр буурсан нь биет бус хөрөнгийн хорогдуулгаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авсан, үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө байхгүй, хандиваар хөрөнгө хүлээн аваагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 307,027.3 мянган төгрөг болж өссөн байна. Энэ нь төслийн өмнөх шат буюу Тогтвортой амьжиргаа-2 төсөл нь Бичил санхүүгийн хөгжлийн

сангаас 2013 онд 201,380.0 ам.долларыг Тогтвортой амьжиргаа-3 төслөөс эргэн төлөх нөхцөлтэй санхүүжилт хүлээн авсныг 2020 онд өглөгөөр бүртгэснээс шалтгаалжээ. Тогтвортой амьжиргаа-2 төслийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг Тогтвортой амьжиргаа-3 төслөөс гаргуулах тухай Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 31-ний 247 тоот тушаалын дагуу уг өглөгийг бүртгэж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж дансанд тайлант оны зардлаар бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,227,452.5 мянган төгрөг болж 168,033.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан үр дүн буурснаас шалтгаалжээ.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 5,033,152.6 мянган төгрөгөөр буюу 25 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь гадаад зээлээр санхүүжих орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 5,576,702.9 мянган төгрөгөөр буюу 27 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж буурсан байна.

Төслийн орлого, зардал буурсан шалтгаан нь төслийн хүрээнд хийгдэхээр төлөвлөсөн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны гарын авлагын сургалт, орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системийг ашиглах аргачлалын сургалт, худалдан авалтын АЗ гэрчилгээ олгох сургалт зэрэг үйл ажиллагаануудыг Ковид 19 цар тахлын улмаас 2021 онд хийхээр хойшлуулсантай холбоотой байна.

Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 18,861.1 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь 2019 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 тоот тогтоолоор балансаас балансад хүлээн авсан 48,500.0 мянган төгрөгийн дансны үнэтэй, 33,680.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй Лексус-470 маркийн авто машиныг шилжүүлэхдээ элэгдлийн зардлыг буруу тооцоолсон дүнгээр шилжүүлсэн тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 4 дүгээр сарын 13-ний өдрийн А/608 тоот албан бичгийн дагуу элэгдлийн зардлыг залруулж бүртгэснээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 14,987,920.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 14,987,920.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 бүрэлдэхүүний хүрээнд авч хэрэгжүүлэх 31 арга хэмжээг санхүүжүүлэхээр 14,987,920.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 10,974,326.8 мянган төгрөгийг гадаадын зээлийн эх үүсвэрээр, 4,013,593.4 мянган төгрөгийг гадаадын тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаадын зээлийн эх үүсвэрээр 10,781,377.6 мянган төгрөг, гадаадын тусламжийн эх үүсвэрээс 3,925,031.4 мянган төгрөг хүлээн авч, урсгал ажиллагаанд 14,418,669.6 мянган төгрөг зарцуулсан. Үүнээс сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны 2019 оны хэрэгжилтэд хийсэн үнэлгээнд үндэслэн 330 суманд нийт 12,058,975.3 мянган төгрөгийн урамшуулал, дэмжлэг олгосон байна.

Хөрөнгийн зардалд 277,760.0 мянган төгрөг зарцуулсан ба орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн системийг байршуулах тоног төхөөрөмжүүдийг худалдан авч, Сангийн яаманд хүлээлгэн өгсөн байна.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан сургалтууд, төслийн зөвлөхийн ажлын хөлс, жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд 2,359,154.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,696,429.7 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа бөгөөд төсөвт тодотгол хийсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 19 төрлийн 149 мэдээллээс 38 мэдээллийг хугацаанд нь, 111 мэдээллийг хугацаа хоцроон шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 35,534.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 359,301.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс, 336,303.1 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 24,799.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ам.долларын харилцах дансны үлдэгдлийг төгрөг рүү хөрвүүлэхдээ Монгол банкны хаалтын ханш ашиглаагүй буюу 8,248.7 мянган төгрөгөөр мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг дутуу илэрхийлсэн;
2. Төслийн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийн сангийн журмыг сурталчлах зорилгоор худалдан авсан нийт 170,405.0 мянган төгрөгийн гарын авлага, бараа материал 2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэлтэй байгаа боловч шууд зардлаар бүртгэсэн;
3. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын нийт 118,519.0 мянган төгрөгийн цалин, 13,940.1 мянган төгрөгийн НДШ-ийн зардлыг "Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр" ангилалд, 11,250.0 мянган төгрөгийн түрээсийн зардлыг өөр өөр ангиллууд буюу Бараа үйлчилгээний бусад зардал, Шуудан холбоо, интернетийн зардалд бүртгэснийг залруулга хийлгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн зөвлөмжөөс бусад залруулагдаагүй 1 алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах 19 төрлийн 149 мэдээллээс 111 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”,

4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” 6 дугаар зүйлийн 6.4.1 “Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илрүүлсэн 24,799.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төслийн худалдан авалтын төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилт нь төслийн гэрээний зорилтод нийцэж буй эсэх нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй. Мөн төслийн Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд 21 аймаг, 330 сумдын орон нутгийн хөгжлийн санд жил бүр олгож буй урамшуулал, дэмжлэг нь хэрхэн үр ашигтай зарцуулагдаж буй эсэх нь энэхүү аудитын цар хүрээнд ороогүй тул аймгуудын Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Аудитын явцад хийсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үндсэн хөрөнгийн тооллогоор нийт 22,998.0 мянган төгрөгийн хөрөнгө Сангийн яамны агуулахад хураалттай буюу төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна. Мөн үндсэн хөрөнгийн бүртгэлд 1,801.8 мянган төгрөгийн бараа материалын шинжтэй хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, "иж бүрэн байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсөл хэрэгжиж дууссаны дараа холбогдох байгууллагад эд хөрөнгийг хүлээлгэн өгөх үед дутагдах, хөрөнгийн чанар муудах.

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн яамны агуулахад байгаа хөрөнгийг цаашид хэрхэн үр дүнтэй ашиглах, ашиглах боломжгүй хөрөнгө, бараа материалын шинж чанартай хөрөнгүүдийг ангилж, холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/43/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Тогтвортой амьжиргаа - 3 төсөл		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Аудитын явцад хийсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үндсэн хөрөнгийн тооллогоор нийт 22,998.0 мянган төгрөгийн хөрөнгө Сангийн яамны агуулахад хураалттай буюу төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна. Мөн үндсэн хөрөнгийн бүртгэлд 1,801.8 мянган төгрөгийн бараа материалын шинжтэй хөрөнгө бүртгэлтэй байна.	24,799.8	Зөвлөмж өгөв.	Төслийн захирал Санхүүгийн ажилтан	Г.Золбоо Т.Түвшинжаргал
2	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн шилэн дансны мэдээллийг шалгахад 149 мэдээллээс 111 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.	-	Албан шаардлага хүргүүлэв.	Төслийн захирал Санхүүгийн ажилтан	Г.Золбоо Т.Түвшинжаргал
ДҮН		24,799.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 136/А0170080
СЯГ-2021/43/СТА-ТХМ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах нийт 19 төрлийн 149 мэдээллээс 111 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тогтвортой амьжиргаа - 3 төслийн захирал Г.Золбоо, санхүүгийн ажилтан Т.Түвшинжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Ц.ЭНХЖАРГАЛ

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Б.АЛТАНСАРНАЙ

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

[illegible]